



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ЭРГЭЛЗЭЭТЭЙ ТОХИОЛДОЛД
АШИГТАЙГААР ШИЙДВЭРЛЭХ
ЗАРЧМЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ЭХ/00/2022/03/06

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2022.04.27



ТОВЬЁОГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

- I. ЭРГЭЛЗЭЭТЭЙ ТОХИОЛДОЛД АШИГТАЙГААР ШИЙДВЭРЛЭХ ЗАРЧМЫН ҮҮСЭЛ
- II. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БАЙДАЛ
- III. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДАЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ
- IV. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ
- V. ШҮҮХИЙН ПРАКТИК

ДҮГНЭЛТ

ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШШ	Анхан шатны шүүх
ДЗШШ	Давж заалдах шатны шүүх
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
ХШШ	Хяналтын шатны шүүх
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль
ЭЗНСЭТОУП	Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХЭТТ	Хүний эрхийн түгээмэл тунхаглал
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт



УДИРТГАЛ

Судлах зүйл

Шүүгдэгчийн гэм буруутай эсхүл гэм буруугүйг тогтоож байгаа шүүхийн шийдвэрт тавигдах шаардлага бол үндэслэл болгосон нотлох баримт нь шүүгдэгчийн гэм бурууг бүрэн дүүрэн нотолж, хэргийн үйл баримтыг үнэн зөвөөр тогтоосон байх билээ. Тухайн хэрэгт хамааралтай нотлох баримтыг бүгдийг шалгасан боловч шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн эсэхэд эргэлзээ гарч, шүүгчид бүрэн дүүрэн итгэл төрөхгүй бол *In dubio pro reo* буюу үндэслэл бүхий аливаа эргэлзээг шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг баримтална. Уг зарчим нь шударга шүүхийн зарчмын нэг сегмент буюу хууль дээдлэх ёсны шууд тусгал болж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /Цаашид ЭХХША гэх/-нд шүүгдэгчийн эрхийг хамгаалдаг.

Энэхүү зарчим нь шүүгдэгчийн гэм буруу хөдөлбөргүй тогтоогдоогүй бол таамаглалд үндэслэж гэм буруутай гэж үзэж болохгүй гэх практик шинжтэй оюун дүгнэлтийг санал болгодог бөгөөд шүүгдэгчийг таамаглалд суурилсан дур зорго, дарангуйллын золиос болохоос хамгаалах эрхийг шүүхэд олгож байгаа юм.

Гадаадын зарим улс орны эрүүгийн процессын хуульд эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал түүнд ашигтайгаар шийдвэрлэх зарчим нь нийтлэг байдлаар тусгагджээ. Харин ЭХХША-ны явцад Эрүүгийн хууль, эрүүгийн процессын хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал ашигтайгаар шийдвэрлэх зохицуулалт нь төдийлөн нийтлэг биш бөгөөд Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан зарим орнуудын эрүүгийн процессын хуульд нийтлэг байдлаар хуульчлагдсан байна.

Хуулийг хэрэглэх гэдэгт эрх зүйн силлогизм хийхийг ойлгодог бол тайлбарлах нь хуулийг тайлбарлах арга зүйтэй холбоотой байна. Хуулийг хэрэглэх явцад хуулийг тайлбарлах шаардлага үүсэх нь түгээмэл бөгөөд ийнхүү тайлбарлахад үүсэх үндсэн бэрхшээл нь тухайн асуудлыг зохицуулж буй хэм хэмжээ хоорондын зөрчилдөөн билээ. Энэхүү хэм хэмжээ хоорондын зөрчилдөөнийг шийдвэрлэх үндсэн 3 зарчим¹ байдаг. Өгүүлж буй зарчмыг тайлбарлах хэрэгцээ шаардлага бий эсэхийг тогтоохдоо хуулийг хэрэглэх, тайлбарлахад шинжлэх ухааны үндэслэлтэй дээрх 3 зарчмыг ашигласан боловч эргэлзээ арилахааргүй нөхцөл өмнө нь үүсэж байсан эсэх, үүсэх боломжтой эсэхийг тодруулах юм. Өөрөөр хэлбэл шүүхээс тодорхой хэм хэмжээг хэрхэн ойлгох талаар тайлбарласан арга болон тухайн хэм хэмжээг ашиглахаар дээр дурдсан зарчмыг сонгосон үндэслэлээ тайлбарлан хэргийг шийдвэрлэхэд хууль хэрэглээний арилах боломжгүй эргэлзээ байх боломжтой эсэхийг судлах нь хууль хэрэглээний арга зүйн хүрээнд шийдвэрлэх боломжтой асуудлыг хууль хэрэглээний эргэлзээтэй хэмээн үзэхээс сэргийлэх ач холбогдолтой болно.

Энэхүү судалгааны ажлаар эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмын онол, түүхэн үүслийг олон улсын эх сурвалж, эрдэмтэн судлаачдын бүтээлээс судлах, Монгол улсын эрүүгийн процессын хуульд тусгагдаж ирсэн уламжлал, гадаадын зарим улс орны эрүүгийн процессын хууль тогтоомжийн зохицуулалттай харьцуулах, үүний зэрэгцээ шүүхээр шийдвэрлэж буй практикийг судалсан болно.

¹ Lex Superior буюу дээд шатны байгууллагаас баталсан хэм хэмжээ давуу хүчинтэй үйлчлэх, Lex Specialis буюу нарийвчилсан зохицуулалт бүхий хэм хэмжээг ерөнхий зохицуулалттай хэм хэмжээнээс тэргүүн ээлжид хэрэглэх, Lex Posterior буюу шинээр баталсан хэм хэмжээ нь өмнө үйлчилж байсан хэм хэмжээнээс давуу хүчинтэй үйлчлэх зэрэг болно.



Судалгааны зорилго

Энэ судалгааны зорилго нь эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмын ойлголтыг тодорхойлох, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад материаллаг болон процессын хуулийг хэрэглэхэд эргэлзээ гарах боломжтой эсэх, эргэлзээ гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх боломжийг судлахад оршино. Тус зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллав. Үүнд:

- Эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмын ойлголт, түүхэн уламжлалыг судлах;
- Эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг олон улсын эх сурвалжид тусгасан үзэл баримтлал;
- Монгол Улсын эрүүгийн процессын хууль тогтоомжид эл зарчмыг хуульчилж ирсэн уламжлалыг судлах;
- Эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмын талаарх эх газрын эрх зүйн бүлд хамаарах гадаадын зарим улсын эрүүгийн процессын хууль тогтоомж дахь эрх зүйн зохицуулалтыг судлах;
- Энэхүү зарчмыг үндэслэл болгож шүүхээр шийдвэрлэж буй практикийг судлахаар тус тус зорьсон болно.

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү зарчмын ойлголт, онцлогийг Монгол Улсын нэгдэн орсон болон бусад олон улсын гэрээ конвенцод хэрхэн тусгасныг, эл сэдвээр бичсэн дотоод, гадаадын илтгэл, бүтээлийг мөн 1994, 2002, 2017 оны эрүүгийн процессын хуулийн хувийн хэргээс хууль тогтоогчийн үзэл баримтлалыг судлах, харьцуулан судлах бусад улс орны хүрээнд захиалагчийн дурдсан АНУ, ХБНГУ-ыг болон судалгааны явцад ач холбогдолтой гэж үзсэн бусад улсын эрүүгийн процессын хууль тогтоомжийг судаллаа. Манай улсын шүүхийн практикт энэхүү зарчмыг хэрхэн ойлгож хэрэглэсэн, тайлбарласныг судлахаар шүүхийн цахим сангаас 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх анхан, давах, хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн болно.



I. ЭРГЭЛЗЭЭТЭЙ ТОХИОЛДОЛД АШИГТАЙГААР ШИЙДВЭРЛЭХ ЗАРЧМЫН ҮҮСЭЛ

Эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчим нь гэм буруугүйд тооцох зарчмаас үүсэлтэй гэж судлаачид үздэг бөгөөд эл зарчим анхнаасаа одоогийнх шиг өргөн хүрээнд хэрэгжиж байгаагүй ч бусад суурь зарчмын адилаар цаг хугацааны явцад аажмаар хөгжиж ирсэн байдаг. Энэхүү зарчмын үүслийг судалгааны бүтээлүүдээс үзэхэд өмнө нь янз бүрийн хэлбэрээр уламжлагдаж ирсэн тул түүхэн эх сурвалжийн талаас нь судлахад ихээхэн бэрхшээлтэй байдаг талаар дурдсан байна. Ашигтайгаар шийдвэрлэх зарчим болон гэм буруугүйд тооцох зарчмын салшгүй уялдаа холбоотой байдлыг харгалзан үзэж дээрх 2 зарчмын үүслийг зэрэгцүүлэн судалбал зохилтой.

Гэм буруугүйд тооцох зарчим нь Ромын иргэний эрх зүйн “idoneare” буюу нотлогдоогүй л бол буруугүй гэсэн үндэслэлд тулгуурлан хөгжсөн², гэм буруугийн презумпцийг (praesumptio boni viri) жичид нь агуулсан хэм хэмжээ тухайн үеийн Ромын иргэний хуульд хамгийн анх удаа тусгагдсан бөгөөд энэ хэм хэмжээнд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид бүгдээрээ шударга (bona fide) гэж үзэгдэх ба хэн нэгэн этгээд тийм бус хэмээвэл тухайн этгээд түүнийгээ нотлох (ei incumbit probatio qui dicit non qui negat) үүрэг хүлээдэг³ байсан нь гэм буруугүйд тооцох зарчим анх Ромын иргэний эрх зүйд тусгалаа олсон гэж үзэхэд хүргэдэг.

Үүний дараа бүр хожим хойно 1789 оны Францын хөрөнгөтний хувьсгалын үед гэм буруугүйд тооцох зарчмыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчмын хэмжээнд хамгийн анх хуульчилсан.⁴ Мөн энэ үйл явдлын талаар эрдэмтэн Б.Бат-Эрдэнэ 1789 онд Францийн хөрөнгөтний хувьсгалын үед батлагдсан “Хүний ба иргэний эрхийн тунхаглал”-д тусгагдсан ба түүнээс хойш баяжин олон улсын конвенц, пакт зэрэг баримт бичигт тусгагдсаар ирсэн түүхтэй гэж тэмдэглэжээ.⁵

“Хүний ба иргэний эрхийн тунхаглал”-ыг Үндэсний хурлын зургаадугаар товчоонд боловсруулж байхад “Шийтгэгдтэлээ хүн бүр гэм буруугүй. Албадан саатуулах зайлшгүй шаардлагатай бол зайлсхийх явдалд нь саад болохоос илүү хатуу арга хэмжээ авбал хүндээр шийтгэнэ” гэсэн хувилбараар оруулж байсан боловч тунхаглалд эцсийн байдлаар “Гэм буруутай гэж шүүхээс зарлагдах хүртлээ хүн бүр гэм буруугүйд тооцогдох учраас шүүхэд албадан ирүүлэхэд шаардагдах илүүц аливаа хатуурхлыг хуулийн дагуу хүндээр шийтгэнэ” гэж тусгасан байна.⁶

Харин *in dubio pro reo* зарчмыг эртний Грекийн сэтгэгч Аристотель, Ромын сэтгэгч Ульпиан нар бүтээлдээ анх тусгаж байсан бол уг зарчмыг хэлбэржүүлэн томъёолох анхны оролдлогыг Миланы хуульч Эгидио Босси хийж байжээ. Харин өдгөө хэрэглэгдэж буйтай төстэй агуулгаар анх 1811 онд Германы эрх зүйч Кристоф Карлын бүтээлд тусгагдсан гэж судлаачид үздэг.

Хуульд тусгалаа олсон үүсэл талаас нь үзэхэд хамгийн анх Ромын эрх зүйн Дигестэд нэр томъёоны хувьд ялгаатай ч агуулгын хувьд ашигтайгаар шийдвэрлэх зарчимтай төсөөтэй хэрэглээг тодорхой заасан хэд хэдэн заалт тусгагдсан байжээ. Тухайлбал, эргэлзээ гарвал эрх чөлөөг дээдэлсэн зохицуулалтыг хэрэглэнэ, хэрэглэхэд эргэлзээтэй зохицуулалт байвал эргэлзээ багатай зохицуулалтыг сонгож хэрэглэнэ, эргэлзээтэй үед

²Д.Зүмбэрэлхам, *Гэм буруугийн презумпчийн зарчмыг Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал*, PhD судалгааны ажил., (МУИС, 2001 он), 19 дэх тал.

³Мөн тэнд, 18 дах тал.

⁴Д.Зүмбэрэлхам, *Гэм буруугийн презумпчийн зарчмыг Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал*, PhD судалгааны ажил., (МУИС, 2001 он), 19 дэх тал., 22 дах тал.

⁵Мөн тэнд, 23 дах тал.

⁶Мөн тэнд, 24 дэх тал.



илүү хүмүүнлэг шийдлийг сонгоно, эрх чөлөөтэй хүн эсхүл боол гэдэгт эргэлзээ үүсвэл эрх чөлөөтэй гэж үзнэ гэх мэт. Гэвч Ромын эрх зүйн үед *in dubio pro reo* зарчим сонгодог утгаараа хэрэгжээгүй гэж үздэг бөгөөд эл зарчмыг хэрэглэснээр ердөө хэргийг дахин шалгаж, нотлох баримтыг сайтар бүрдүүлэх л үр дагавар үүсдэг байж.⁷ Өөрөөр хэлбэл энэ үед *in dubio pro reo* зарчмыг хэрэглэснээр шүүгдэгчийг цагаатгах үр дагавар үүсдэггүй байжээ.

1789 оны Францын хөрөнгөтний хувьсгалтай холбоотойгоор эрүүгийн процессын эрх зүйд гарсан өөрчлөлтүүдэд *in dubio pro reo* зарчим тусгагдаж, улмаар европ тив даяар уг зарчмыг агуулсан Наполеоны гэх тодотголтой эрүүгийн процессын хуулиар (1808 он) дамжуулан цаашид түгээн дэлгэрэх үндэс болжээ.

In dubio pro reo зарчмын үзэл баримтлал нь эрх зүйн ач холбогдолтой үйл баримтад үүссэн аливаа эргэлзээг шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх, мөн шүүгдэгчийн гэм бурууг нотолж байгаа үйл баримтууд хөдөлбөргүй нотлогдож байхыг шаарддаг. Эргэлзээтэй тохиолдолд шигтайгаар шийдвэрлэх болон гэм буруугүйд тооцох зарчим нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга явагдах зорилгыг хангахын тулд зэрэгцэн үйлчилдэг байна.⁸ Орчин цагийн эрүүгийн процесст гэм буруугүйд тооцох зарчмыг хүлээн зөвшөөрснөөрөө шүүх гэм буруугүй болохыг нь тогтоосноор цагаатгахаас гадна гэм буруутай нь нотлогдохгүй бол гэм буруугүйд тооцож цагаатгах болсон.

II. ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ, БУСАД ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНД ТУСГАГДСАН БАЙДАЛ

2.1 Европын хүний эрхийн шүүх дэх *In dubio pro reo* зарчмын практик

Шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчим нь олон улсын шүүхийн практикт нэвтэрсэн ойлголт бөгөөд Страсбург дэх Европын хүний эрхийн шүүх (Цаашид ЕХЭШ гэх) нь дээрх зарчмын хэрэглээтэй холбоотой Европын хүний эрхийн конвенц (цаашид ЕХЭК гэх) болон үндэсний хууль тогтоомжийн уялдаа холбооны талаарх хэд хэдэн хэргийг шийдсэн байна.

Дээрх шийдсэн хэргүүд нь ЕХЭК-ийн 6-р зүйлийн 2 дах хэсэгт тусгагдсан гэм буруугүйд тооцох зарчим түүнд агуулагдаж буй *In dubio pro reo* зарчим болон тус конвенцын мөн зүйлийн 1 дэх хэсэгт заасан шударга шүүхээр шүүлгэх эрхийн зөрчил гарсан эсэхийг ЕХЭШ хянан үзсэн юм.

Хорватын эсрэг Песагийн хэргийг хэлэлцэх явцад ЕХЭШ “6-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэм буруугүйд тооцох зарчим нь шударга шүүхийн нэг хэсэг юм” хэмээн казуал тайлбар хийсэн бөгөөд гэм буруугүйд тооцох зарчим нь *in dubio pro reo* зарчимтай нягт холбоотой. Шүүх шийдвэрийнхээ үндэслэлийг тодорхой тайлбарласнаар шударга шүүхээр шүүлгэх эрх зохих ёсоор хэрэгжсэн гэж үзэх ЕХЭК-ийн практикт тогтсон ойлголт байдаг бөгөөд энэ нь *in dubio pro reo* зарчим зөрчигдсэн эсэхийг шүүхийн шийдвэрээс тодорхой харах боломжийг олгодог⁹.

ЕХЭШ Хорватын эсрэг Аждарикийн хэрэгт шүүхийн дүгнэлт хангалттай үндэслэл бүхий байх шалгуурыг хангаагүйгээс *in dubio pro reo* зарчим зөрчигдсэн гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Тус дүгнэлтэд “Улсын яллагч үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байдлаар

⁷ Dimitrevski, Zoran, et al. Doubt in favour of the defendant, Guilty beyond reasonable doubt - Comparative study, Mishevska, Ljubica (ed.), OSCE Mission to Skopje, 2016, p. 16.

⁸ „When it comes to acquittal, the right to presumption of innocence would be emptied of all its significance without this principle, since any doubtful situation would not be solved in favor of the defendant anymore[...]And *vice versa*, without the right to presumption of innocence, the principle of *in dubio pro reo* would be of hardly any benefit to the defendant, since the suspect should bear the burden of proving their innocence.“ (Dimitrevski, Z., et al., op.cit., p. 72).

⁹ (PDF) [In dubio pro reo principle in modern criminal procedure \(researchgate.net\)](#)



нотлох эрүүгийн эрх зүйн суурь шаардлага зөрчигдөөд байхад Үндэсний шүүх үүнд дүгнэлт өгөөгүй, мөн ашигтайгаар шийдвэрлэх эрүүгийн эрх зүйн суурь зарчим зөрчигдсэн байна” хэмээжээ.

2.2 Англо-Америкийн эрх зүй дэх *In dubio pro reo* зарчим

Англо-Америкийн эрх зүйн тогтолцоонд гэм бурууг тогтоохдоо маш тодорхой байх шаардлагыг баримталдаг бөгөөд үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх *beyond reasonable doubt* гэх зарчмаар Англо-Америкийн эрх зүйд илэрдэг. Эх газрын эрх зүй дэх *in dubio pro reo* зарчмаас ялгаатай нь илүү явцуу утгаар тайлбарладаг. Тухайлбал, зөвхөн гэм буруугийн асуудлыг л хөнддөг буюу гэмт хэрэг мөн эсэхийг тодорхойлох, ял шийтгэл оногдуулах явдалд хэрэглэдэггүй байна¹⁰.

Үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх зарчим нь эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчимтай ижил цаг хугацаанд бий болсон бөгөөд 1798 онд АНУ-ын дээд шүүх ийм санааг илэрхийлсэн зарчмыг томьёолсон гэж үздэг. Whitmen уг зарчмын талаар өөрийн байр суурийг илэрхийлэхдээ “энэ зарчим нь яллагдагчийг хамгаалж байгаа хэрэг биш харин тангарагтнуудын сүнсийг хараалаас хэлтрүүлж байгаа юм” хэмээжээ¹¹. Энэхүү тогтолцоонд мөн л үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх зарчим нь гэм буруугүйд тооцох зарчимтай салшгүй нягт холбоотой гэж үздэг ажээ.

2.3 Олон улсын баримт бичигт тусгагдсан байдал

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹² -ын 11 дүгээр зүйл. Гэмт хэрэгт шалгагдаж буй хэн бүхэн өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ баталгаатай эдэлж, шүүхээс гэм бурууг нь хуульд заасны дагуу тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдоно.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг. Гэм бурууг нь хуульд заасны дагуу тогтоох хүртэл гэмт хэрэгт шалгагдаж буй хэн бүхэн гэм буруугүйд тооцогдох эрхтэй.¹³
- Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм¹⁴-ийн 66 дугаар зүйл. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд заасны дагуу шүүхээс гэм бурууг нь тогтоох хүртэл хэн бүхэн гэм буруугүйд тооцогдоно.
- Европын зөвлөлийн Хүний суурь эрх чөлөө, эрхийг хамгаалах конвенц¹⁵-ын 6.2 дугаар зүйл. Хуульд заасны дагуу гэм бурууг тогтоох хүртэл гэмт хэрэгт шалгагдаж буй хэн бүхнийг гэм буруугүйд тооцно. хэмээн олон улсын шинж чанартай үндсэн 4 баримт бичигт уг зарчмыг тусгасан байдаг байна.
- Канадын хүний эрх, эрх чөлөөний тунхгийн 11-ийн “д” зүйлд¹⁶ “Гэмт хэрэгт шалгагдаж буй хэн боловч хөндлөнгийн хараат бус шударга, ил тод шүүхээр хуулийн дагуу шүүлгэж гэм буруу нь тогтоогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй.”
- Колумбын Үндсэн хуулийн 2 дахь хэсгийн, 1-р бүлгийн 29-р зүйлд “Хүн бүр хуулийн дагуу гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэм буруугүй байна.”

¹⁰ Мөн тэнд.

¹¹ Мөн тэнд.

¹² НҮБ-ийн Ерөнхий Ассамблей 1948 оны 12-р сарын 10-ны өдөр баталсан

¹³ НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн тогтоолоор 1966 оны 12-р сарын 16-нд батлагдаж, 1976 оны 3-р сарын 23-ны өдрөөс үйлчилж эхэлсэн олон улсын гэрээ. Монгол Улс 1968 оны 6-р сарын 5-ны өдөр нэгдэн орохоо илэрхийлж гарын үсэг зурж, 1974 оны 11-р сарын 18-ны өдөр соёрхон баталж, 1976 оны 3-р сарын 23-ны өдрөөс үйлчилж эхэлсэн.

¹⁴ Олон улсын Эрүүгийн шүүхээс 1998 оны 7-р сарын 17-ны өдөр баталж, 2002 оны 7-р сарын 1-ний өдрөөс үйлчилж эхэлсэн. Монгол Улс 2000 оны 12-р сарын 29-ны өдөр нэгдэн орохоо илэрхийлж гарын үсэг зурж, 2002 оны 4-р сарын 11-ний өдөр соёрхон баталж, 2002 оны 7-р сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

¹⁵ Европын зөвлөлөөс 1950 оны 11-р сарын 4-ний өдөр баталж, 1953 оны 9-р сарын 3-ны өдрөөс үйлчилж эхэлсэн.

¹⁶ Guide to the Canadian Charter of Rights and Freedoms - Canada.ca.



- 1789 оны Францын Хүний ба иргэний эрхийн тунхгийн 9-р зүйл-д¹⁷ “Хэн боловч гэм буруу нь тогтоогдох хүртэл гэм буруугүй байна.”

III. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДАЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан нь гэм буруугүйд тооцох зарчим анх удаа МУҮХ-д тусгагдсан юм.

Зарим эрдэмтэн, судлаачид гэм буруугүйд тооцох зарчмыг Үндсэн хуулиас өмнө ЭБШХ-д тусгагдсан гэж үздэг бөгөөд О.Нямдаваа өөрийн бүтээлдээ “1963 оны ЭБШХ-ийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ЭБШ ажиллагаа нь..., гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож буюу эрүүгийн ял оногдуулахгүйн тулд алив хэргийг түргэн шуурхай...” гэж заасан хуулийн зорилгыг баримтлан гэм буруугүйд тооцох зарчим ЭБША-д хуульчлагдан хэрэглэгдэж байгаа талаар дурдаж байжээ¹⁸ гэсэн хэдий ч энэ нь жинхэнэ утгаараа гэм буруугүйд тооцох зарчим үйлчилж байсан гэх үндэслэлгүй юм.

ЭБШХ-ийн 1994 оны 3 дугаар сарын 28-ны нэмэлт, өөрчлөлтөөр 17/1/ дүгээр зүйлд “Шүүхийн таслах шийдвэрлэх тогтоолгүйгээр хэнийг боловч гэмт хэрэг үйлдсэнд тооцож, эрүүгийн ял шийтгэл оногдуулахгүй” мөн “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч яллагдагчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ төрвөл, түүнчлэн эрүүгийн болон ЭБШХ-ийг тайлбарлах, хэрэглэхэд гарах эргэлзээг яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх¹⁹”-ээр заасан нь гэм буруугүйд тооцох зарчим анх удаа ЭБШХ-д хуульчлагджээ гэж үзэж болохоор байна.

1994 онд ЭБШХ-д нэмэлт, өөрчлөлт хийх болсон нэгэн хүчин зүйл нь 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталснаар Монгол Улс 1970 оны дунд үеэс нэгдэн орсон ИБУТЭТОУП, ЭЗНСЭТОУП зэрэг хүний эрхийн талаарх олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс хүний эрхийг хангах зарчмыг дотоодын хууль тогтоомжид тусгах шаардлага бий болсон гэж үздэг байна.²⁰

Монгол Улсын ЭБШХ тогтоомжийн хөгжлийг үндэсний ардчилсан хувьсгал хүртэл үе, социалист байгууллын эхэн үеийн хууль тогтоомж, социалист байгууллын дараах үеийн хууль тогтоомж гэсэн гурван үе шатанд авч үздэг²¹ бөгөөд 1994 оны ЭБШХ-ийн нэмэлт, өөрчлөлт нь түүхэн цаг үеийн хувьд социалист байгууллын дараах үеийн хууль тогтоомжид²² хамаарч байна.

Дээрх нэмэлт, өөрчлөлтийн талаар эрдэмтэн Б.Баярсайхан өөрийн бүтээлдээ “Шүүхийн шийдвэр нь шүүгдэгчийн гэм бурууг гарцаагүй нотлох баримт дээр тулгуурлах, нотолгоо болон хуулийн тайлбар эргэлзээтэй байвал сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг тусгажээ”²³ гэж тэмдэглэсэнээс үзвэл энэ үеэс эхлэн эргэлзээтэй тохиолдолд ашигтай шийдвэрлэх зарчмыг эрүүгийн процесст хэрэгжиж эхэлсэн гэж үзсэн үндэслэл улам батжиж байна. /1994 оноос 2017 оныг хүртэлх хугацаанд

¹⁷ [Declaration Rights of Man 1793 \(columbia.edu\)](http://www.columbia.edu/~l17/Declaration%20Rights%20of%20Man%201793.html).

¹⁸ О.Нямдаваа нар, БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, 1987 он, 40 дэх тал. Дам эшлэв.

¹⁹ М.Алтангэрэл, Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 1994 он, 9 дэх тал.

²⁰ Б.Баярсайхан нар, Монголын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), УБ., 2012 он, 62 дах тал.

²¹ Мөн тэнд, 7 дэх тал.

²² Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, 2005, 11 дэх тал.

²³ Б.Баярсайхан нар, Монголын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), УБ., 2012 он, 63 дах тал.



эрүүгийн процессын хуулийн гэм буруугүйд тооцох зарчимд хийсэн нэмэлт, өөрчлөлтийг доорх хүснэгтээс харьцуулан харна уу./

№	Эрүүгийн процессын хууль	1 дэх хэсэг	2 дахь хэсэг
1.	1994 оны нэмэлт, өөрчлөлт	17/1/. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.	Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч яллагдагчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ төрвөл, түүнчлэн эрүүгийн болон ЭБШХ-ийг тайлбарлах, хэрэглэхэд гарах эргэлзээг яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэнэ.
2.	2002 он	13.1 Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй.	Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ.
3.	2017 он	1.15 Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй.	Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.

Дээрх бүлгээс нэгтгэн дүгнэхэд, эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчим нь 1994 оны 03 дугаар сарын 28-ны нэмэлт, өөрчлөлтөөр ЭБШХ-д хуульчлагдсан байна. Эрүүгийн процессын хууль тогтоомж нь Эрүүгийн хууль болон тухайн үеийн нийгмийн хөгжлийн чиг хандлагатай холбоотойгоор шинэчлэн өөрчлөгдөж, процессын эрх зүйн салбарын уламжлалыг хадгалан хууль зүйн техникийн хувьд боловсронгуй болсоор ирсэн бөгөөд дээрх заалтад хамаарах субъект нэмэгдсэнийг эс тооцвол агуулгын хувьд өөрчлөгдөөгүй байна.

Эрдэмтэн, судлаачид эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх агуулгыг хэрхэн ойлгож хэрэглэхийг өөрийн бүтээлдээ хэрхэн тэмдэглэснийг авч үзэхэд:

- Б.Гунгаа нарын бүтээлд “Гэм буруутай эсэх нь нотлогдсон эсэх талаар гарсан эргэлзээг гэм буруугүй нь нотлогдсонтой адилтган үзэх үндэслэл болсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах шийдвэр гаргах нь тэдэнд ашигтайгаар шийдвэрлэх гэсэн ойлголтыг илэрхийлнэ.”²⁴;
- Б.Баярсайхан өөрийн бүтээлдээ “Энэхүү зарчим нь ЭХХШТХ-ийн зорилготой салшгүй холбоотой гэж үзсэн бөгөөд шүүхээс хэргийг мөрдөн байцаалтад болон

²⁴Б.Гунгаа нар, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар, 2003 он, 18 дах тал.



прокурорт буцаах нь ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасантай харш бөгөөд эрх зүйн үндэслэлийн хувьд зохисгүй практик²⁵ ;

- Эрдэмтэн С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ “Эргэлзээг тайлбарлах” гэдэг нь хэргийг мөрдөн шалгах буюу хянан шийдвэрлэх явцад яллагдагч (шүүгдэгч) гэм буруутай эсэх асуудлаар эргэлзээ үүсэхэд эрүүгийн шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлж буй төрийн байгууллага буюу албан тушаалтны үйлдлийн арга. Шүүхийн тогтоол гарахад яллагдагчийн гэм буруу эргэлзээгүй нотлогдсон ба тогтоогдсон байх ёстой бөгөөд мөрдөгч, прокурор ба шүүх нэгэнт үүссэн эргэлзээг шалгах ба арилгах талаар хуульд заасан мөрдөн байцаалтын ба процессын бусад үйлдлийг хийж гүйцэтгэх бүхий л нотлох арга хэмжээг авах ёстой. Хэрэв объектив шалтгааны улмаас түүнийг арилгаж болохооргүй байвал яллагдагчид ашигтайгаар тайлбарлах ёстой. Үүнээс гадна гэм буруутай эсэх эргэлзээг хэрэв арилгаж чадахгүй бол ЭХ ба ЭХХШТХ-ийг хэрэглэх явцад үүссэн эргэлзээг яллагдагчид ашигтайгаар тайлбарлах ёстой²⁶ гэж тус тус тэмдэглэсэн байна.

3.1 Эрүүгийн процессын хуулийн хувийн хэрэг

Энэ бүлгээр бид 1994, 2002, 2017 оны эрүүгийн процессын хуулийн төслийн хувийн хэргээс энэхүү зарчимтай холбоотой хууль тогтоогчийн үзэл баримтлалыг судлахаар зорьсон болно.

1994 оны ЭБШХ-ийн хуулийн төслийн танилцуулгаас дурдвал “Хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, төр, хуулийн байгууллагын зүгээс хууль зүйн үндэслэлгүйгээр хүний эрх, эрх чөлөөнд халдах явдал гаргуулахгүй байх нөхцөл бүрдүүлэхэд онцгой анхаарч шүүхийн шийдвэр нь шүүгдэгчийн гэм бурууг гарцаагүй нотлох баримт дээр тулгуурлах, нотолгоо болон хуулийн тайлбар эргэлзээтэй байвал сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг тусгав”²⁷ гэжээ. Хууль зүйн байнгын хороо болон УИХ-аар хэлэлцүүлэх үед эл зарчмыг өөрчлөх талаар хэлэлцээгүй бөгөөд хуулийн хувийн хэргээс үзэхэд зөвхөн техникийн шинжтэй засвар оруулсан байна.

2002 оны ЭБШХ-ийн төсөлд тусгасан үзэл баримтлалаас дурдвал “Хоёрдугаар бүлгийг шинээр бий болгож эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт, зарчмуудыг тусгав. Энэ бүлэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчмуудын онцлогийг харуулан тусгаж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хууль ёсны байх зарчмыг нэмж оруулав” гэжээ.

Гэм буруугүйд тооцох зарчимтай холбоотой УИХ-ын гишүүн Б.Эрдэнэбат “Төслийн 13.2-т заасан ЭБШХ-ийн суурь зарчмуудын нэгийг тус төслийн Хэргийг бүртгэх, мөрдөн байцаалтад буцаах гэсэн 231-р зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5 дахь хэсгүүд болон 251-р зүйлд заасан Шүүх хуралдаанаас тогтоол, захирамж гаргах журам гэсэн зүйлийн 2-т ..., хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах, ... тухай асуудлыг зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ гэсэн заалтуудаар хэрэгжих үндэсгүй болгож байгаа”²⁸ талаар ЭБШХ-ийн төсөлд өгөх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор гаргаж байжээ.

Мөн дээрх хувийн хэрэгт ЭБШХ-ийн эцсийн найруулгад 13.2 дахь хэсэгт хийсэн засварыг харахад “..., Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”

²⁵Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, 2020 он, 104 дэх тал.

²⁶С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Хууль зүй дотоод хэргийн яам, 2021 он, 336 дахь тал.

²⁷Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн хувийн хэрэг, 1994 он, 1, 2 дах талууд.

²⁸Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, хуулийн хувийн хэрэг 1-р боть, 2002 он, 236 дах тал.



гэж төсөлд тусгасан байсныг “.., Эрүүгийн хууль болон энэ хууль” гэж техникийн шинжтэй засвар оруулж²⁹ мөн түүнчлэн, “.., түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ.” гэж энэхүү зарчимд хамаарах субъектийг нэмж зассан байна.³⁰

2017 оны ЭХХШТХ-ийн төслийн танилцуулгад “Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн талаар тусгаж, энэхүү урьдчилсан хэлэлцүүлгийн тогтолцоо бий болсноор шүүхээс прокурорт хэрэг буцаахгүй байхаар тусгалаа. Ингэснээр Үндсэн хууль болон энэ хуульд заасан гэм буруугүйд тооцох зарчим хэрэгжих боломж бүрдэх юм” мөн түүнчлэн, “ЭБША-ны аливаа шатанд хамаарах гэм буруугүйд тооцогдох эрх нь шүүхийн шатанд илүү чухал ач холбогдолтой. Гэм буруугүйд тооцогдох эрхийн дагуу шүүх бүрэлдэхүүн өөрийн үүргээ хэрэгжүүлэхдээ яллагдагч тухайн яллаж буй хэргийг үйлдсэн гэсэн урьдчилсан бодолтой шүүх хурлыг эхлүүлж болохгүй, гэм бурууг нотлох нь прокурорын үүрэг бөгөөд ямар нэгэн үндэслэл бүхий эргэлзээ төрвөл тэр нь яллагдагчид ашигтайгаар хэрэглэгдсэн байх, тухайн этгээдийн гэм бурууг нотлох баримтаар үндэслэлтэй, эргэлзээ төрөхгүйгээр нотлогдсон бол гэм буруутай гэж үздэг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн хуулийн төслийн шүүх хуралдааны хэсгийг боловсруулсан талаар”³¹ тус тус дурдсан байна.

Энэхүү зарчмын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр “Шүүхээс хэргийг буцаасан шалтгаан үндэслэлийг нь судлаад үзэхээр шүүх энэ бол хангалттай нотлогдохгүй байна. Гэхдээ нотлоод ир гээд явуулж байгаа. Энэ маань өөрөө ҮХ-ийн гэм буруутай нь шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчимтай бас нийцэхгүй байгаа. Шүүхээс гэмт хэрэг үнэхээр хангалттай нотлогдсон нь тогтоогдож байгаа бол ялаа оноох ёстой. Хангалттай нотлох баримт байхгүй, нотлогдохгүй байгаа бол хэрэгсэхгүй болгох ёстой. Эсхүл цагаадах ёстой”³², мөн түүнчлэн, “Урьдчилж ямар нэгэн байдлаар яллах байр суурь дээр байж болохгүй. Гагцхүү цугларсан нотлох баримт талуудын мэтгэлцээнд үндэслэж байж хөндлөнгийн байр сууринаас энэ хэрэг маргааныг таслан шийдвэрлэх ёстой. Гэм буруутай нь шүүхээр шүүхийн шийдвэр гарах хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй гэдэг энэ ҮХ-ийн зарчим бол шүүхэд өөрт нь ч гэсэн хамаатай гэдэг үзэл баримтлалыг бол баримталж төслийг боловсруулсан байгаа”³³ талаар дурдаж байжээ.

Дээрхээс нэгтгэн дүгнэхэд, хууль тогтоогчоос ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэм буруугүйд тооцох зарчим шүүхийн шатнаас хэргийг прокурорт буцаадаг зохицуулалттай зөрчилддөг гэж үзэж байгаа нь харагдаж байна. Хэрэв гэм буруутай эсэхэд эргэлзээ үүссэн тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж шийдвэрлэхээр тусгагджээ гэж үзэж болохоор байна. 1994, 2002, 2017 оны эрүүгийн процессын хуулийн хувийн хэргийг үзэхэд хууль тогтоох шатанд эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчим ямар нэгэн байдлаар дурдаагүй, ихэвчлэн техникийн шинжтэй засвар өөрчлөлтүүд л орж байжээ.

IV. ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ

Бүгд Найрамдах Албани улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 4 дүгээр зүйлд. Шүүхийн шийдвэрээр эцэслэн шүүгдэгчийн гэм бурууг тогтоох хүртэл түүнийг гэм буруугүй гэж үзнэ. Шүүгдэгчийн гэм бурууг тогтоохтой холбоотой гарсан аливаа эргэлзээг түүний

²⁹Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, хуулийн хувийн хэрэг 2-р боть, 2002 он, 7 дэх тал.

³⁰Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, хуулийн хувийн хэрэг 4-р боть, 2002 он, 7 дэх тал.

³¹Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувийн хэрэг 1-р боть, 2017 он, 19 дэх тал.

³²Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувийн хэрэг 2-р боть, 2017 он, 29 дэх тал.

³³Мөн тэнд, 34 дэх тал.



талд ашигтайгаар шийдвэрлэнэ. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь үндэслэл бүхий эргэлзээгүйгээр тогтоогдож байвал шүүхээс түүнийг гэмт буруутайд тооцно.³⁴

Бүгд Найрамдах Армени улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 18 дугаар зүйлд. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болоогүй бөгөөд энэ хуульд зааснаар шүүгдэгчийн гэм бурууг эцэслэн тогтоох хүртэл гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж буй аливаа этгээдийг гэм буруугүйд тооцно. Сэжигтэн, яллагдагч нь гэм буруугүй болохоо нотлох үүрэг хүлээхгүй. Цагаатгах талд сэжигтэн, яллагдагчийг гэм буруугүй болохыг нотлох үүргийг хүлээлгэж болохгүй. Яллах нь үндэслэлтэй болохыг нотлох, сэжигтэн, яллагдагчийн талд ашигтай байх үндэслэлийг няцаах үүргийг улсын яллагч хүлээнэ. Хүнийг гэмт хэрэг үйлдсэн талаар таамаглалд үндэслэн дүгнэж болохгүй. Аливаа дүгнэлт нь гагцхүү хэрэгт хамаатай, уялдаа холбоотой, эргэлзээгүй, хангалттай нотлох баримтуудаар нотлогдож байх ёстой. Гэм бурууг тогтоох явцад энэ хуульд заасан журмаар арилгах боломжгүй аливаа эргэлзээг сэжигтэн, яллагдагчийн талд ашигтайгаар тайлбарлана.³⁵

Бүгд Найрамдах Эстони улсын Эрүүгийн процессын хуулийн 7 дугаар зүйлд. Хүний гэм бурууг тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө хэнийг ч гэм буруутай гэж үзэж болохгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийнхөө гэм бурууг нотлох үүргийг хэн ч хүлээх ёсгүй. Сэжигтэн, яллагдагчийн гэм бурууг тогтоох явцад арилгах боломжгүй аливаа эргэлзээг сэжигтэн, яллагдагчийн талд ашигтайгаар шийдвэрлэнэ.³⁶

Гүрж улсын Эрүүгийн процессын хуулийн 5 дугаар зүйлд. Шүүхийн эцсийн шийдвэрээр гэм буруу нь тогтоогдох хүртэл хүнийг гэм буруугүйд тооцно. Өөрийн гэм буруугүй болохыг нотлох үүргийг хэн ч хүлээх ёсгүй. Яллахад шаардлагатай нотлох бүх үүргийг улсын яллагч хүлээнэ. Улсын яллагч яллахаас татгалзаж болно. Хуульд заасан журмаар нотлох баримтыг үнэлэхэд эргэлзээ гарвал яллагдагчийн талд ашигтайгаар шийднэ. Хүнийг цагдан хорих үндэслэлгүй бол нэн даруй суллана.³⁷

Бүгд Найрамдах Казахстан улсын Эрүүгийн процессын хуулийн 19 дүгээр зүйлд. Энэ хуульд заасан журмын дагуу шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр шүүгдэгчийн гэм бурууг тогтоох хүртэл түүнийг гэм буруугүйд тооцно. Хэн ч өөрийн гэм буруугүй болохоо нотлох үүргийг хүлээхгүй. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруугийн талаар арилшгүй эргэлзээ үүсвэл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн талд ашигтайгаар тайлбарлана. Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хуулийг хэрэглэхэд эргэлзээ үүсвэл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэнэ. Шүүхийн шийдвэр нь хуульд заасан журмаар цуглуулсан, найдвартай нотлох баримтуудад үндэслэх бөгөөд таамаглалд үндэслэж болохгүй.³⁸

Бүгд Найрамдах Киргиз улсын Эрүүгийн процессын хуулийн 15 дугаар зүйлд. Шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм бурууг нь тогтоох хүртэл хүнийг гэм буруугүй гэж үзнэ. Шүүгдэгч гэм буруугүй болохоо нотлох үүргийг хүлээхгүй. Эрүүгийн процессын журмаар шийдвэрлэх боломжгүй яллах талын нотлох баримтад үүссэн аливаа эргэлзээг шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэнэ. Эрүүгийн хууль, Эрүүгийн

³⁴[Albania CPC 1995 am2017 en.pdf \(legislationline.org\).](#)

³⁵[CRIMINAL PROCEDURE CODE \(legislationline.org\).](#)

³⁶[Code Criminal Procedure 2003 am2020 en.pdf \(legislationline.org\).](#)

³⁷[Preview \(legislationline.org\).](#)

³⁸[KAZ CPC as of 2019 eng.pdf \(legislationline.org\).](#)



процессын хуулийг хэрэглэхэд үүссэн аливаа эргэлзээг шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэнэ.³⁹

Бүгд Найрамдах Молдова улсын Эрүүгийн процессын тухай хуулийн 8 дугаар зүйлд. Энэ хуульд заасан журмаар цагаатгах талын эрхийг баталгаатай эдлүүлж, шүүхээс гэм бурууг нь эцэслэн тогтоох хүртэл гэмт хэрэгт шалгагдаж буй хүнийг гэм буруугүй гэж үзнэ. Өөрийн гэм буруугүй болохоо нотлох үүргийг хүлээхгүй. Хүнийг гэм буруутайд тооцсон дүгнэлт нь таамаглалд үндэслэж болохгүй. Энэ хуулиар арилгах боломжгүй аливаа эргэлзээг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн талд тайлбарлана.⁴⁰

Бүгд Найрамдах Солонгос улсын Эрүүгийн процессын хуулийн 257-2 дугаар зүйлд “Гэм буруу нь шүүхээр тогтоогдох хүртэл шүүгдэгчийг гэм буруугүй гэж үзнэ” гэж хуульчилжээ.⁴¹

Бүгд Найрамдах Азербайжан улсын Эрүүгийн процессын хуулийн 21 дүгээр зүйлд. Шүүхээс гэм бурууг эцэслэн тогтоох хүртэл, энэ хуульд заасны дагуу гэм буруутай болохыг нотолж чадаагүй бол гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж буй хүнийг гэм буруугүйд тооцно. Хүний гэм буруугийн талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал гэм буруутайд тооцож болохгүй. Энэ хуулийн дагуу гэм бурууг тогтооход арилгах боломжгүй аливаа эргэлзээ нь яллагдагч (сэжигтэн)-д ашигтайгаар ашиглагдана. Мөн Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хуулийг хэрэглээд арилгах боломжгүй аливаа эргэлзээ гарвал яллагдагч (сэжигтэн)-д ашигтайгаар ашиглагдана. Яллагдагч гэм буруугаа нотлох үүргийг хүлээхгүй. Сэжигтэн, яллагдагчийг цагаатгах талын нотлох баримтыг няцаах, түүний гэм бурууг нотлох үүргийг прокурор хүлээнэ.⁴²

Холбооны Бүгд Найрамдах Герман улсад Холбооны улсын Үндсэн хууль болон Эрүүгийн процессын хуульд шууд тусгагдаагүй. Харин Үндсэн хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн Хүний эрхийн Европын конвенцийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “хууль дээдлэх ёс/эрх зүйт төр”⁴³-нэг хэсэг болж тусгагдсан байдаг. Гэм буруугүйд тооцох зарчим нь хууль дээдлэх ёсны дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар гэм бурууг нь тогтоох хүртэл яллагдагчийг гэм буруугүй гэж тооцох тухай юм. Эрүүгийн процессын тухай хуулийн 112 дугаар зүйлд заасны дагуу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр цагдан хорих тухай шийдвэр гаргахдаа гэм буруугүйд тооцох зарчмыг зөрчиж, таамаглалд үндэслэж болохгүй тухай заасан байдаг.⁴⁴

Бүгд Найрамдах Босни Херцеговина Улсын Эрүүгийн процессын хуулийн 3 дугаар зүйлд. Шүүхийн эцсийн шийдвэрээр гэм буруу нь тогтоогдох хүртэл хэнийг ч гэм буруугүй гэж үзнэ. Гэмт хэргийн шинжийг бүрдүүлж буй үйл баримтын оршихуйн талаар эргэлзээ байгаа эсхүл эрүүгийн хуулийн тодорхой заалтыг хэрэглэхтэй холбоотой эргэлзээ үүсвэл шүүх шүүгдэгчид ашигтай байдлаар шийднэ гэж заасан байна.

Европ дахь аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагаас эрхлэн гаргасан харьцуулсан судалгааны бүтээлд⁴⁵ эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг дараах байдлаар тайлбарласан.

³⁹[KYR_CPC_am2008_en_ok\(4\).pdf](#).

⁴⁰[Moldova_CPC_2003_am2016_en.pdf \(legislationline.org\)](#).

⁴¹[Statutes of the Republic of Korea \(klri.re.kr\)](#).

⁴²[Legislationline](#).

⁴³ Rule of law.

⁴⁴ [germany-2021-country-research-presumption-innocence_en.pdf \(europa.eu\)](#).

⁴⁵ Doubt in favour of the defendant, guilty beyond reasonable doubt: Comparative study in 2016 by Organization for Security and Co-operation in Europe.



ХБНГУ-ын эрх зүйд тус зарчмыг хэрхэн ойлгож, тайлбарлаж байгаа талаар товч

А. Шийдвэр гаргахад шууд, гол ач холбогдолтой үйл баримт

Эрүүгийн процесст шийдвэр гаргахад үйлчилдэг бичигдээгүй нэг эрх зүйн зарчим байдаг нь, эргэлзээтэй тохиолдолд (in dubio) шүүгдэгчид ашигтайгаар (pro geo) шийдэх билээ. Энэ зарчмын эрх зүйн мөн чанар нь маргаантай байдаг. Судлаачдын нэг хэсэг нь уг зарчим материаллаг эрх зүйд хамаарна гэж үздэг бол нөгөө хэсэг нь процессын эрх зүйн хэм хэмжээ, тэр дундаа эрүүгийн процессын нотолгооны зохицуулалт гэж маргадаг. /энэ талаар Hanack, Loewe/Rosenberg, ЭХХШТХ, 24 дэх хэвлэлт, 337 дахь тал, хажуугийн дугаар 14/ Хэргийг шийдэж буй шүүгч нотлох баримт тус бүрийг хэрхэн үнэлэхийг зааварлаж буй асуудал биш гэдэг нь маргаангүй. Нотлох баримтыг үнэлж дууссаны эцэст шууд нотолгооны ач холбогдол бүхий үйл баримтын хувьд, жишээлбэл гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж байгааг илэрхийлэх үйл баримтын тухайд гаргаж болох ямар нэг эргэлзээгүй бол яригдаж эхлэх зарчим юм. Нотлох баримтыг үнэлэх хүрээнд тодорхой ач холбогдолтой байдаг сэжиг төрөх мөчүүдэд нэмэлтээр энэ зарчмыг хэрэглэж болохгүй. Нотлогдоогүй үйл баримтад тулгуурлаж буруутгаж болохгүй, учир нь шүүгчийн итгэл үнэмшил ямар нэг боломж, эсхүл төсөөлөл, урьдчилсан таамаглалд үндэслэх ёсгүй. Эрүүгийн хэргийн шүүгч нь нотлох баримтыг судалснаар тухайн бодит байдал байна гэсэн бүрэн хэмжээний итгэл үнэмшил аваагүй л бол шүүгдэгчид тухайн тохиолдолд хамгийн ашигтай эрх зүйн үр дагаврыг бий болгох ёстой гэж дүгнэж байжээ. /Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, MDR, 1975, 468/ Эргэлзээ юунд хүргэж болох вэ гэхээр, шүүгдэгчийг суллах ёстой, учир нь шүүгдэгчийн зөрчсөн гээд байгаа эрүүгийн хэм хэмжээний бүрэлдэхүүн нотлогдоогүй билээ. Түүнчлэн хуралдаан эхлэхэд дурдаж байсан зүйл ангиас өөр “зөөлөн” зүйл ангиар ял шийтгэгдэхэд хүрч болох, мөн эрүүгийн хариуцлагыг үгүйсгэх, хүчингүй болгох, эсхүл хуульд заасан хөнгөрүүлж үзэх шалтгаануудыг хэрэглэх ёстой болгож болох юм. Энэ зарчим төөрөгдөх, гарцаагүй байдал, гэм буруутай байх чадвар, хүндрүүлсэн гэмт хэргүүд эсэх /хүнд хэлбэрийн хулгай, хүнд хэлбэрийн дээрэм, дээрх замаар олж авсан хөрөнгийг байнгын ашгийн төлөө үйл ажиллагааны шинжтэйгээр худалдах гэмт хэрэг/ асуудалд хэрэглэгддэг.

Б. Процессын урьдач нөхцөл

Бүхий л процесст хамаарах, урьдач нөхцөл хангагдсан эсэх дээрх эргэлзээ хэрхэн нөлөөлөх талаар нэгдсэн зарчим гэж байх боломжгүй хэмээн Холбооны Дээд Шүүхийн Эрүүгийн хэргийн танхим тайлбар гаргасан⁴⁶. Процессын урьдач нөхцлийг төрөл тус бүр дээр тодорхойлж явах нь зүйтэй гэсэн агуулгатай. Жишээлбэл, насных нь хувьд гаргаж болохоор эргэлзээ байхгүй тохиолдолд шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх / BGHSt, 5, 366 NJW, 1954, 847/, хүчин төгөлдөр өргөдөл, гомдол гэж үзэх, оршин байгаа эсэхийг тогтоох / BGHSt, 22, 90, 93, NJW, 1968, 1148 /, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай хуулийг хэрэглэхэд ач холбогдолтой, гэм бурууг үндэслэх нөхцөл байдал байгаа эсэхийг тогтоох /BGH JR, 1954, 351/8 Бавари муж улсын эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн эмхтгэл, 1968, 75 NJW, 1968, 2118, маргаантай/, мөрдөх хөөн хэлэлцэх хугацаа болсон тухай /BGHSt, 18, 274 NJW, 1963, 1209/

В. Процессын бусад үйл баримтын тухай

Процессын бусад үйл баримтын тухай дээрх зарчим үйлчлэхгүй. Процессын зөрчлийн тухай эргэлзээ үлдвэл, зөрчлийг үндэслэлээ болгож буй процессын оролцогч талын ашиг сонирхлын эсрэг үйлчлэх болно. Учир нь, эсрэг зүйлээ нотолж чадахгүй бол процесс хуульд нийцэж явагдсан гэж үздэг. /BGHSt, 16, 164, 167 NJW, 1961, 1979/ тиймээс

⁴⁶ BGHSt, 18, 274 NJW, 1954, 847.



давж заалдахаас татгалзахаа шүүгдэгч илэрхийлж буй илэрхийлэл нь эргэлзээтэй, шүүх хуралдаанд оролцох чадвар нь эргэлзээтэй байхад татгалзлыг хүчин төгөлдөр гэж үзнэ. /BGH NStZ, 1984, 329/ Мөн худал мэдээлэлд үндэслэж давж заалдсаныгаа буцаан татах ч адил үр дагавартай.

Г.Эрх зүйн асуудал

Хуулийг тайлбарлах болон эрх зүйн бусад асуудлаар *in dubio pro reo* зарчим үйлчлэхгүй. харин эргэлзээтэй тохиолдолд илүү зөөлөн хуулийг хэрэглэх зарчим буюу *in dubio mitius* тусдаа эрх зүйн зарчим юм.⁴⁷

Зарчмыг хэрэглэх цар хүрээ, цаг хугацаа:

Иргэнлэг эрх зүйн тогтолцооны улсуудын тодорхойлсон байдлаар энэхүү зарчимд анализ хийж үзвэл уг зарчим нь 2 сегментээс бүрдэж байна. Эхнийх нь эргэлзээ бий болоход тавигдах урьдчилсан нөхцөл болон үүнд чухам юуг хамааруулж болох талаар заасан байдаг бол хоёр дахь нь ийм эргэлзээ үүссэн бол шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэх тухай юм.

Аль улсын шүүхийн харьяалалд багтаж буйгаас хамааран тухайн гэмт хэргийг тодорхойлсон заалт, эрүүгийн материаллаг болон процессын хуулийн бусад заалтыг хэрэглэхэд хамааралтай үйл баримтад эргэлзээ үүсэж болно.

Гэмт хэргийг тодорхойлохтой холбоотой үйл баримт гэдэгт гэм буруутай оюун санаа⁴⁸, гэм буруутай үйл хөдлөл⁴⁹ байсныг нотолсон үйл баримт байгаа эсэх тухай асуудал хөндөгддөг бол ЭХ-ийн бусад заалтын хэрэглээтэй холбоотой үйл баримт гэдэгт гэмт хэрэг гэж тооцогдохгүй үйлдэл эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бусад үндэслэлүүдийг хамруулж авч үздэг.⁵⁰ Тухайлбал, аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, хууль зүйн болон бодит андуурал, сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй байдал бөгөөд өөрөөр хэлбэл шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн эсэхтэй холбоотой үйл баримт бий эсэхэд эргэлзээ үүсвэл шүүхээс *in dubio pro reo* зарчмыг хэрэглэж, түүнийг цагаатгана гэсэн үг.⁵¹

Эрүүгийн процессын хуулийн хэрэглээтэй холбоотой үйл баримтад эргэлзээ гарвал ижил зарчмаар шийддэг. Тухайлбал хөөн хэлэлцэх хугацаа хэзээ эхэлсэн, тасалдсан эсэх гэх мэт цэвэр үйл баримтын хувьд дууссан эсэхэд нь эргэлзээ гарвал уг зарчмыг ашиглан хэргийг хэрэгсэхгүй болгоно.⁵²

Харин тус зарчим нь туслах үйл баримтын хувьд хэрэглэгддэггүй. Туслах үйл баримт нь эрх зүйн ач холбогдол бүхий үйл баримтын эх сурвалжийг зааж байдаг. Тэдний чиг үүргийг авч үзвэл зөвхөн бусад үйл баримтыг магадлан шалгах ач холбогдолтой юм. Жишээ нь гуравдагч этгээдийн хуурамчаар үйлдсэн, сэжигтний гэмт хэрэг үйлдсэн болохоо илчилсэн захиаг хуурамч эсхүл жинхэнэ эсэх нь туслах шинжтэй, эрх зүйн ач холбогдол бүхий үйл баримтын эх сурвалжийг магадлахад л ашиглагдаж байх тул түүнд гарч буй эргэлзээнд тусад нь *in dubio pro reo* зарчмыг хэрэглэх шаардлагагүй юм.⁵³

⁴⁷ Deutsches Rechtslexikon, Verlag C.H.Beck, Band 2, 496-497.

⁴⁸ mens rea

⁴⁹ actus reus

⁵⁰ OSCE, Doubt in favor of the defendant, guilty beyond reasonable doubt: Comparative study ., 2016, p.74

⁵¹ Мөн тэнд.

⁵² OSCE, Doubt in favor of the defendant, guilty beyond reasonable doubt: Comparative study ., 2016, p.75

⁵³ Мөн тэнд.



Мөн энэхүү зарчим нь эрүүгийн материаллаг болон процессын хуулийн заалтыг тайлбарлахад хэрэглэгддэггүй.⁵⁴ Хуулийг тайлбарлаж, хэрэглэнэ гэдэг нь хуулиас тодорхой харилцааг зохицуулсан *ratio legis* буюу эрх зүйн үндэслэлийг олох тухай ойлголт болно. Хэргийн үйл баримтыг шүүхээс судалсны дараа хуульд байгаа хамгийн зөв шийдлийг олж тухайн хэргийг шийдвэрлэх нь нэг талаас шүүхийн эрх, нөгөө талаас чиг үүрэг нь юм. Харин уг зарчмын хүрээнд хуулийн агуулгыг шүүгдэгчид ашигтайгаар тайлбарлаж, хэрэглэх тухай ойлголт байх боломжгүй. Өөрөөр хэлбэл хуулийг тайлбарлан хэрэглэх нь эргэлзээг шийдвэрлэх тухай биш харин хуулийг зөв хэрэглэх тухай агуулгыг хөнддөг.⁵⁵

*Жишээ нь: Отолтод оруулж хүнийг алах гэмт хэрэг нь ердийн байдлаар хүнийг алах гэмт хэрэгтэй адилгүй, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм гэх тайлбарыг шүүхээс хийсэн гэж үзье. Магадгүй энэ тайлбар нь тухайн үед шүүгдэгчид ашигтайгаар үйлчилсэн байж болох ч энэ нь in dubio pro reo зарчмын үр дүн биш, “ердийн байдлаар” гэх гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг шинжийг тодорхойлсон нэр томъёонд хийсэн тайлбар юм.*⁵⁶

V. ШҮҮХИЙН ПРАКТИК

Шүүхийн цахим сангаас 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд “1.15, эргэлзээ” гэх түлхүүр үгээр эрүүгийн хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүхийн шийдвэрийг шүүж ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг хэрхэн тайлбарлаж хэрэглэсэн, шийдвэрлэсэн байдлыг энэ бүлэгт нэгтгэн судалсан болно.

5.1 Анхан шатны шүүхийн шийдвэр

Дээрх хугацаанд АШШ-ээр ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэж шийдвэрлэсэн **51** шүүхийн шийтгэх тогтоол байгаагаас нотлох баримт эргэлзээтэй тул ашигтайгаар шийдвэрлэсэн **46**, хууль эргэлзээтэй тул ашигтайгаар шийдвэрлэсэн **5** шүүхийн шийтгэх тогтоол байна.

Гэм буруутай эсэхийг тогтооход нотлох баримт эргэлзээтэй тохиолдлуудыг нэгтгэн авч үзэхэд гэрчийн мэдүүлгүүд хоорондоо зөрүүтэй, эсхүл эд мөрийн баримт болон гэрчийн мэдүүлэг хоорондоо зөрүүтэй мөн түүнчлэн, хамтран гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчийн оролцоог шууд нотолж байгаа нотлох баримт байхгүй тохиолдлууд хамаарч байна. Харин хууль хэрэглэхэд эргэлзээтэй тохиолдол үүсэж шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн үндэслэлийг доорх хүснэгтээр авч үзэхэд:

№	Шүүхийн шийдвэрийн дугаар	Эргэлзээтэй хууль	Шүүхийн шийдвэрт дурдсан эргэлзээ
1.	2021/ШЦТ/80	тодорхойгүй	ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...” гэж заасан байх тул шүүгдэгч З.Г-ийг гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, түүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал зэргийг тус тус харгалзан ЭХЕА-ийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан ЭХТА-ийн 24.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял

⁵⁴ Мөн тэнд.

⁵⁵ OSCE, Doubt in favor of the defendant, guilty beyond reasonable doubt: Comparative study ., 2016, p.76

⁵⁶ Мөн тэнд.



			оногдуулахгүйгээр 2 жилийн хугацаагаар тэнсэх нь зохимжтой гэж шүүх дүгнэв.
2.	2021/ШЦТ/118	Эрүүгийн хууль	Амь хохирогч С.Б бэртэл гэмтэл, өвчтэй байгаагүй боловч хүчтэй согтолтын улмаас биеэ авч явах болон өөртөө тусламж үзүүлэх, бусдаас тусламж хүсэх чадваргүй байсан нь хэрэгт авагдсан баримтуудаар хангалттай тогтоогдож байгаа бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.2 дугаар зүйлд бусад шалтгааны улмаас өөрийгөө хамгаалах, өөрийнхөө төлөө анхаарал халамж тавих боломжгүй хүний эрүүл мэнд, амь насыг тухайн гэмт хэргийн объект болгож хуулийг хэрэглэхэд эргэлзээтэй байх тул ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгч нарт ашигтайгаар шийдвэрлэх үндэслэлтэй байна гэж шүүх бүрэлдэхүүн үзэж, хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч В.Р, Б.Л, Э.М нарыг цагаатгаж шийдвэрлэлээ.
3.	2021/ШЦТ/669	Эрүүгийн хууль, ЭХХШТХ	Эрүүгийн болон ЭХХШТХ нь өөр хоорондоо зохицуулах зүйлийн хувьд ялгаатай ч зарим тохиолдолд тухайлсан зарим зохицуулалтынх нь утга агуулга, хэрэглээ давхцах, эргэлзээтэй зарим утга агуулга, хэрэглээг нарийвчлан тодотгосон шинжтэй байх зэрэг зохицуулалтын холимог шинжийг агуулсан байхыг үгүйсгэх боломжгүй буюу тухайн хуулиудыг хэрэглэх, тайлбарлахад зарим эргэлзээ үүсэх тохиолдол байдаг. Үүний нэг илрэл нь гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь эдгэрэхгүй, өөртөө эсхүл бусдад аюул учруулахааргүй байгаа бол хэрхэн шийдвэрлэхтэй холбоотой Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 4, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 19.3 дугаар зүйлийн 4.2, 4.3, 4.4 дэх заалт, тэдгээрийн шууд ба шилжсэн утга агуулга, хэрэглээний хүрээнд үүсэж буй зарим эргэлзээ гэж ойлгож болно. Тийнхүү гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь эдгэрэхгүй, өөртөө эсхүл бусдад аюул учруулахааргүй байгаа тухайн тохиолдолд түүнд эрүүгийн хариуцлагын төрөл болох эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхэд хамааралтай Эрүүгийн болон ЭХХШТХ-ийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг хэрэглэх, тайлбарлах хүрээнд үүссэн аливаа эргэлзээ бүрийг шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх үндэслэлтэй гэж ойлгоно.



			<p>Иймд шүүгдэгч Б.Д нэгэнт “аливаа үйл явдал, асуудал”-ыг бүрэн хэмжээгээр ухамсарлах чадваргүй буюу эдгэршгүй өвчтэй, тус өвчний улмаас өөртөө болон бусдад аюул учруулахгүй болох нь шинжээчийн дүгнэлтүүдээр тогтоогдсон байх тул нэгэн адил сэтгэцийн өвчтэй, тус өвчин нь эдгэрэхгүй, өөртөө болон бусдад аюул учруулахааргүй шүүгдэгч нарт зөвхөн “гэмт хэрэг үйлдэхийн өмнө эсхүл гэмт хэрэг үйлдсэний дараа тухайн өвчнөөр өвчилсөн эсэх”-ээр нь ялгаварлал үүсгэх, тэгш бус, хүнлэг, энэрэнгүй бус байдлаар хандах үндэслэлгүй учраас шүүгдэгч Б.Д-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлэх нь МУҮХ-р баталгаажуулсан иргэний эрх, нийтлэг зарчим, Эрүүгийн хуульд заасан нийтлэг зарчим, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журам, тэдгээрийн утга агуулга, шалгуур шаардлагад хамгийн зүй зохистойгоор нийцнэ гэж дүгнэв.</p>
4.	2021/ШЦТ/32	ЭХ	<p>Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна” гэж заасан байх бөгөөд шүүгдэгч Г.Д-н хөдөлгөөнт утсыг дээрх зохицуулалтад хамааруулж хураахад эргэлзээтэй байх тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх нь зүйтэй гэж дүгнэлээ.</p>
5.	2021/ШЦТ/38	ЭХ	<p>ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 8-д... шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болно..., мөн хуулийн 13-д... шүүх, прокурор, мөрдөгч тухайн хэрэгт хамааралтай энэ хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь хянан үзнэ ... гэж заасны дагуу мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч, хохирогч нарын өгсөн мэдүүлгийн дагуу шүүгдэгч Н.Н болоод “..... оргил” нөхөрлөлд гэм буруутай үйлдэлд Эрүүгийн хуулийг хэрэглэхэд гарсан буюу хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон, дээрх эргэлзээ бүрийг шүүгдэгчид ашигтайгаар</p>



		шийдвэрлэж, Аймгийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 1-т зааснаар шүүгдэгч Н.Н, мөн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3-т зааснаар шүүгдэгч хуулийн этгээд “..... оргил” нөхөрлөл-д тус тус холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж шийдвэрлэх нь үндэслэлтэй гэж үзэв.
--	--	---

Дээрх хүснэгтийн 1, 4, 5 дугаарт заасан шүүхийн шийдвэрийг үзвэл ЭХ болон ЭХХШТХ-ийг хэрэглэхэд ямар бодитой эргэлзээ гарсан нь ойлгомжгүй байх бөгөөд шүүгч ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэхгүйгээр шийдвэрлэх боломжтой байсан гэж судлаачдын зүгээс дүгнэж байна. Харин 2 болон 3 дугаарт заасан шүүхийн шийдвэрт хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарсан гэж үзэх боломжгүй юм. Тухайлбал, 2 дугаар хэргийн тухайд Эрүүгийн хуулийн 15.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн диспозицид заасан субъектүүдэд амь хохирогч хамаарахгүй байх тул тухайн гэмт хэргийн объектив тал үгүйсгэгдэж байна. Харин 3 дугаар хэргийн хувьд шүүгдэгчид хүлээлгэх хариуцлага, авах арга хэмжээний талаар ЭХ, ЭХХШТХ-д ялгамжтай заасан буюу хэм хэмжээ хоорондын зөрчилдөөн бий болсон байна. Уг зөрчилдөөнийг шийдвэрлэх үндсэн 3 зарчим⁵⁷ байдаг талаар өмнөх бүлэгт дурдсан билээ. Шүүхээс Lex Specialis буюу нарийвчилсан хэм хэмжээг тэргүүнд ээлжинд сонгож хэрэглэх зарчмаар хэргийг шийдвэрлэсэн байх боловч, дээрх хэм хэмжээ хоорондын зөрчилдөөнийг эргэлзээ хэмээн дүгнэсэн байна.

5.2 Давж заалдах шатны шүүхийн шийдвэр

Дээрх хугацаанд ДЗШШ-ээр ашигтайгаар шийдвэрлэх зарчимтай холбоотой **33** магадлал shuukh.mn сангаас олдсон бөгөөд үүнээс **11** шийтгэх тогтоолыг in dubio pro reo зарчмыг үндэслэлгүйгээр хэрэглэсэн гэж үзэж тухайн шүүхэд буцааж шийдвэрлэсэн байна. Буцаасан үндэслэлийг авч үзэхэд АШШ нотлох баримтыг үндэслэлтэй дүгнээгүй, хэргийн бодит байдалтай нийцээгүй, нотлох баримтад тулгуурлахгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон, нотлох баримтыг хэрхэн няцаасан, үгүйсгэсэн үндэслэл тодорхойгүй зэрэг шалтгаан дийлэнх хувийг эзэлж байна.

№	Дугаар	Үндэслэл
1.	2022/ДШМ/01	Шинжээчийн дүгнэлт болон хохирогчийн эмнэлгийн тусламж авсан он, сарын хувьд эргэлзээтэй нөхцөл байдал үүссэн байхад дээрх хуулийн заалтыг үндэслэн шүүгдэгчийг цагаатгах боломжгүй юм.
2.	2021/ДШМ/960	Нотлох баримтуудыг үндэслэлтэйгээр няцаан үгүйсгэж чадаагүй, өөрөөр хэлбэл цагаатгах тогтоол нь ЭХХШТХ-д заасан “хөдөлбөргүй, эргэлзээгүй байдлаар хэргийн бодит байдлыг тогтоох, шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх” нотолгооны стандарт шаардлагыг илтэд хангаагүй байна.
3.	2021/ДШМ/757	Дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авахдаа бусдыг нь үгүйсгэсэн үндэслэлийг заагаагүй.
4.	2021/ДШМ/30	Нотлох баримтуудын хүрээнд үндэслэл бүхий дүгнэлтийг АШШ хийгээгүй байх тул ЭХХШТХ-ийн 36.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт

⁵⁷ Lex Superior, Lex Specialis, Lex Posterior.



		“Шүүгдэгчийн холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол гаргана” гэсэн хуулийн заалттай нийцээгүй байна.
5.	2021/ДШМ/59	Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхэд эргэлзэх ямар эргэлзээ гарсан талаар шүүх үндэслэл бүхий дүгнэлт хийгээгүй байна.
6.	2021/ДШМ/26	ЭХХШТХ-ийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасантай нийцээгүй байна.
7.	2021/ДШМ/05	Шүүх мөрдөн шалгах ажиллагаа хийсэн боловч олж тогтоогдохгүй байгаа зүйлийг заавал олж тогтоо гэж дахин дахин буцааж яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулахын оронд ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хэргийг прокуророос ирүүлсэн яллах дүгнэлтийн буюу нотлогдсон хүрээнд дүгнэлт хийж шийдвэрлэх нь зүйтэй байжээ гэж үзлээ.
8.	2021/ДШМ/1068	ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хангалттай нотлон тогтоогдоогүй нь гэмт хэргийн шинжийг шалгах, нотлох, үгүйсгэх, түүнтэй холбоотой дүгнэлт хийх ажиллагаа хийх шаардлагагүй нөхцөлд хүрсэн гэж дүгнэж түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна.
9.	0065	Нотлох баримтын нотолгооны ач холбогдол, хамаарал хууль ёсны байдлыг дүгнэн шинжилж, харилцан эсрэг болон нэгдмэл сонирхолтой байж болох этгээдүүд болох хохирогч Б.У, гэрч Д.Б, Ц.У, С.А нарын мэдүүлгүүдийг хэрхэн няцаан үгүйсгэсэн үндэслэл тодорхойгүй байна.
10.	2021/ДШМ/735	Хэргийн бодит байдалтай нийцээгүй
11.	2021/ДШМ/01	Нотлох баримтад тулгуурлахгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч нарыг цагаатгасан нь үндэслэлгүй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

5.3 Хяналтын шатны шүүхийн тогтоол

2021 онд ХШШ-ээр ашигтайгаар шийдвэрлэх зарчимтай холбоотой 6 шийтгэх тогтоол байгаа бөгөөд зөвхөн нотлох баримт эргэлзээтэй байх тохиолдлууд хамаарч байна. 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 213 дугаартай тогтоолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг дараах байдлаар тайлбарлажээ.

Хүний гэм бурууг тогтоохын тулд хуульд заасан арга, хэрэгслээр шаардлагатай бүхий л ажиллагааг хийсний эцэст шүүхийн шийдвэрт нөлөөлж болох тодорхой эргэлзээ үүсээгүй, эсхүл уг үүссэн эргэлзээтэй гэх асуудлыг шүүх заавал няцаан үгүйсгэсэн байх ёстой бөгөөд няцаан үгүйсгэгдэхгүй бол тэрхүү эргэлзээг тухайн хүнд ашигтайгаар шийдвэрлэх буюу “In dubio pro re” гэсэн эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим нь үндэслэлгүйгээр яллах ба шийтгэх явдлыг гаргуулахгүй байх, хүний эрхийг хамгаалах агуулгыг илэрхийлдэг бөгөөд манай улсын ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгалаа олсон байна. Энэхүү зохицуулалт нь мөрдөгч, прокуророос хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн шалгаж, хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтуудыг гүйцэд бүрдүүлж, хэргийг шүүхэд шилжүүлсний эцэст хэрэгт цугларсан баримтуудаар хэргийн үйл баримтыг бодитой тогтоож чадаагүй, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутайг хөдөлбөргүй тогтоож, эрх зүйн дүгнэлт хийхэд эргэлзээ үүссэн тохиолдолд сая тэдгээрт ашигтайгаар буюу гэм буруугүйд тооцож, гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр цагаатгаж шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт юм.



ДҮГНЭЛТ

Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэж тохирох ял, шийтгэлийг оногдуулах шийдвэрийг гаргахын тулд шүүгч болсон үйл баримтын талаарх үнэн зөв байдлыг бүрэн дүүрэн тогтоох ёстой. Өөрөөр хэлбэл ЭХХША-ны үр дүнд гарах аливаа шийдвэрт тавигдах шаардлага нь нотлогдсон үйл баримтад тулгуурлах явдал юм. Эрүүгийн эрх зүй дэх шударга ёсны зарчмын гол агуулга нь гэм буруугүй нэгнийг яллахаас зайлсхийдэг учир эл зорилгыг биелүүлэхийн тулд шүүхээс тодорхой үйл баримтын талаар эргэлзээ төрвөл шүүгдэгчийн талд ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг эрүүгийн процессын онол, практикийн хөгжлийн явцад нээн илрүүлсэн байдаг.

Гэм буруугүйд тооцох зарчим нь хамгийн анх Ромын иргэний эрх зүйд хэрэглэгдэж байсан бөгөөд хожим Францийн хөрөнгөтний хувьсгалаас үүдэн байцаан шийтгэх ажиллагаанд гэм буруугүйд тооцох зарчим хуульчлагдсан нь өнөө үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын баримт бичгүүдэд тусгагдах эхлэл болсон бөгөөд зөвлөмжийн шинж чанартай тусгасан зарчим одоо улс орон бүр өөрийн эрүүгийн процессын шинжтэй хууль тогтоомжид заавал тусгах зарчим болж хүлээн зөвшөөрөгджээ.

In dubio pro reo буюу эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчмыг улс бүр өөрийн эрүүгийн процессын хууль тогтоомжид нийтлэг байдлаар тусгасан байх бөгөөд үйл баримтад эргэлзээ үүсэх эсхүл хуульд эргэлзээ үүсэх гэсэн 2 төрлөөр хуваагдсан байна. Албани, Азербайжан, Армени, Эстони, Гүрж, Молдова зэрэг улсад шүүгдэгчийн гэм бурууг тогтооход арилах боломжгүй эргэлзээ гарвал ашигтайгаар шийдвэрлэх зарчим нийтлэг байдлаар хуульчлагдсан байх бол Азербайжан, Казахстан, Киргиз, Босни Херцеговина зэрэг улс нь манай улстай адилхан зохицуулалттай буюу нотлох баримт, ЭХ болон ЭХХШТХ-ийг хэрэглэхэд эргэлзээ гарсан тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэхээр энэхүү зарчмыг өргөн хүрээтэй хуульчилжээ. Мөн ХБНГУ болон БНСУ нь in dubio pro reo зарчмыг огт хуульчлаагүй байгаа нь онцлог байна.

Манай улсад эргэлзээтэй тохиолдолд ашигтайгаар шийдвэрлэх зарчим бусад улсын адилаар гэм буруугүйд тооцох зарчимтай уялдаа холбоотой байдлаар хуульчлагдсан нь 1994 оны ЭБШХ-д нэмэлт, өөрчлөлтөөс харагдаж байна. Энэхүү зарчимд орсон өөрчлөлтөөс харахад тус зарчимд хамаарагдах этгээдүүд нэмэгдсэнээс өөрөөр агуулгын шинжтэй өөрчлөлт ороогүй мөн түүнчлэн, хууль батлах үед хэлэлцээгүй зарчмын зөрүүтэй санал тусгаж байгаагүй зохицуулалт байна.

In dubio pro reo зарчмыг хэрэглэж буй шүүхийн практикийг 2021 оны шүүхийн шийдвэрүүдээс нэгтгэн дүгнэхэд, хяналтын шатны шүүх болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдэд дээрх зарчмыг адилхан тайлбарлаж хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл хяналтын болон давж заалдах шатны шүүхэд энэхүү зарчим зөвхөн нотлох баримтын хүрээнд хэрэглэгдэж байна. Харин анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоос дүгнэхэд хууль хэрэглэхэд гарсан эргэлзээ гэхээс илүү тухайн шүүгчийн хууль хэрэглэх ур чадвартай холбоотой байж магадгүй юм.

Харьцуулсан судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэхэд манай улсын ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эх газрын эрх зүйн бүлд” хэрэглэгддэг *in dubio pro reo* буюу эргэлзээтэй тохиолдолд шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх зарчим тусгагджээ. Харин “нийтлэг эрх зүйн бүлд” *beyond reasonable doubt* буюу үндэслэл бүхий эргэлзээнээс ангид байх зарчим үйлчилдэг байна. Эхний зарчим нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх үйл баримт бий эсэхэд хүрч үйлчилдэг өргөн хүрээний хэрэглээтэй бол удаах зарчим нь зөвхөн шүүгдэгчийн гэм бурууг тогтоохтой холбоотой үйл баримтыг тодорхойлоход үүссэн эргэлзээнд л үйлчлэх явцуу шинжтэй байна.



In dubio pro reo зарчим нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх үйл баримтын оршихуйд үүссэн эргэлзээнд хэрэглэгддэг учир эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудын хуульд “эрүүгийн материаллаг, процессын хуулийг тайлбарлах, хэрэглэхэд” үүссэн эргэлзээнд хэрэглэнэ гэх байдлаар тусгагдсан байна. Үүнийг холбогдох онолын эх сурвалжуудаас судлан үзэхэд хуулийг тайлбарлах, хэрэглэхтэй холбоотой оюун дүгнэлт гаргахад үүсэх эргэлзээ биш, харин хуулийг тайлбарлан хэрэглэх урьдчилсан нөхцөл бүрдсэн эсэх буюу үйл баримт бодитоор байсан эсэхийг тогтооход үүссэн эргэлзээг зааж буй талаар дурдсан байна.



ЭХ СУРВАЛЖ

ХУУЛЬ ТОГТООМЖ:

- Монгол Улсын Үндсэн хууль //Төрийн мэдээлэл, Уб., 1992 он №1
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль //Төрийн мэдээлэл, Уб., 2017 он, №23
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

НОМ, ӨГҮҮЛЭЛ, ТАЙЛАН:

- Шүүхийн ерөнхий зөвлөл, *Эдийн засгийн гэмт хэрэг гарын авлага*, Уб., 2017 он
- Д.Зүмбэрэллхам, *Гэм буруугийн презумпчийн зарчмыг Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал*, PhD судалгааны ажил., (МУИС, 2001 он)
- О.Нямдаваа нар, БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Уб, 1987 он
- М.Алтангэрэл, Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Уб., 1994 он
- Б.Баярсайхан нар, Монголын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогмоомжийн түүхэн уламжлал (1911-2009), Уб., 2012 он
- Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Уб., 2005
- Б.Гунгаа нар, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар, Уб., 2003 он
- Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, Уб., 2020 он
- Organization for Security and Co-operation in Europe. *Doubt in favour of the defendant, guilty beyond reasonable doubt: Comparative study* ., 2016
- С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, Хууль зүй дотоод хэргийн яам, Уб., 2021 он
- Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн хувийн хэрэг, 1994 он
- Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, хуулийн хувийн хэрэг, 2002 он
- Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хувийн хэрэг, 2017

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ:

- [\(PDF\) In dubio pro reo principle in modern criminal procedure \(researchgate.net\)](#)
- ХБНГУ-ын Эрүүгийн процессын хууль: [StPO - englisch \(legislationline.org\)](#)
- БНАУ-ын Эрүүгийн процессын хууль: [Albania CPC 1995 am2017 en.pdf \(legislationline.org\)](#)
- БНАрУ-ын Эрүүгийн процессын хууль: [CRIMINAL PROCEDURE CODE \(legislationline.org\)](#)
- БНСУ-ын Эрүүгийн процессын хууль: [Statutes of the Republic of Korea \(klri.re.kr\)](#)
- БНАЗУ-ын Эрүүгийн процессын хууль: [Azerbaijan - Legislationline](#)
- БНЭУ-ын Эрүүгийн процессын хууль: [Estonia - Legislationline](#)
- Гүрж улсын Эрүүгийн процессын хууль: [Georgia - Legislationline](#)
- БНКаУ-ын Эрүүгийн процессын хууль: [Kazakhstan - Legislationline](#)
- БНКиУ-ын Эрүүгийн процессын хууль: [Kyrgyzstan - Legislationline](#)
- БНМоУ-ын Эрүүгийн процессын хууль: [Moldova - Legislationline](#)
- Монтенегро улсын Эрүүгийн процессын хууль: [Montenegro - Legislationline](#)
- ОХУ-ын Эрүүгийн процессын хууль: [Russian Federation - Legislationline](#)